

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

2023

(Энэхүү тайлан дахь тоон мэдээллүүд нь Энержи Ресурс групп компаниудын хэмжээний нэгдсэн дүн болно)

I. КОМПАНИЙН ТУХАЙ	1
II. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	2
III. ЗАСАГЛАЛ	3
IV. БАЙГАЛЬ ОРЧИН	5
V. АЖИЛЛАГСАД	9
VI. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ	11
VII. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ	13
VIII. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА	15
IX. ШАГНАЛ	21



I. КОМПАНИЙН ТУХАЙ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.



Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний уул уурхайн компани бөгөөд 2009 оноос хойш Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар шууд ба шууд бусаар нийт 7,000 орчим хүнийг ажлын байраар хангахын зэрэгцээ үндэсний 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй урт хугацаанд хамтран ажиллаж ирлээ. Мөн татвар төлөлт, нийгмийн хариуцлагаар Монгол Улсын ТОП 5 компанийн жагсаалтанд сүүлийн арван таван жил тасралтгүй бичигдэж байна.

2010 онд Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Бид олборлолт, баяжуулалт, тээвэр, экспортыг цогцоор шийдсэн, дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уурхайн үйл ажиллагаа эхэлсэн цагаас Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Төвөөс 560 км алслагдмал говийн суманд Нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, ус хангамжийн систем, 650 айлын орон сууц, 1,000 гаруй хүүхдийн багтаамжтай

сургууль, цэцэрлэгийн цогцолбор зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж байгуулахдаа шаардлагатай боловсон хүчнийг сургаж бэлтгэх, сум орон нутагтай байнгын эргэх холбоотой хамтын ажиллагаа хөгжүүлэх бүхий л боломжуудыг бүрдүүлж ажилласан.

Бид нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг анхнаас нь бодитой, зөв хэрэгжүүлэхэд анхаарч бодлого чиглэлээ олон улсын КНХ-ын сайн дурын стандарт ISO:26000-д нийцүүлэн боловсруулсан.

Мөн Монголын уул уурхайн салбарт анх удаа Чанарын удирдлага (ISO 9001:2015), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага (HSAS 18001:2007), Байгаль орчны удирдлага (ISO 14001:2015) олон улсын стандартуудаар Менежментийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Уг тогтолцоог нэвтрүүлснээр үйл ажиллагааны бүхий л үе шатанд мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулан, олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

КНХ, байгаль орчин, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй салшгүй холбоотой байдаг.

II. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

НҮБ-аас дэлхий дахинаа тунхагласан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилсан, тогтвортой хөгжилд хүрэх урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Уг баримт бичгийн нийт 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын болон төр, төрийн бус, хувийн хэвшил, олон нийт зэрэг бүхий л оролцогч талуудын идэвхи санаачлага, хамтын оролцоо нэн чухал гэж тодорхойлсон байдаг.

Манай улсын хувьд 2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бичиг баримтыг баталсан.

Энержи Ресурс компани нь олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулж, тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Энэ дагуу 2011 онд Тогтвортой хөгжлийн бодлого, 2012 онд Компанийн нийгмийн хариуцлагын бодлогоо боловсруулан баталж, үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хэрэгжүүлэн ажилласаар ирсэн. Бид компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын бүхий л үзүүлэлт, үйл ажиллагаагаа Тогтвортой хөгжлийн 17 зорилтод нийцүүлж, нягт уялдуулах зарчмыг баримталж, уг санаачлагыг дэмжин ажиллаж байна. Цаашид байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлтүүд, тэдгээрт хамааралтай эрсдлүүдийг нарийн тодорхойлохын хэрээр Тогтвортой хөгжлийн зорилтуудад харгалзах үр дүнгийн үзүүлэлтүүд нарийвчлагдан гарах юм.

- 1 ядуурлыг устгах
- 2 өлсгөлөнг устгах
- 3 эрүүл мэндийг дэмжих
- 4 чанартай боловсролыг дэмжих
- 5 жендерийн эрх тэгш байдлыг хангах
- 6 баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
- 7 сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
- 8 эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөрийг дэмжих
- 9 инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
- 10 тэгш бус байдлыг бууруулах
- 11 ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
- 12 хариуцлагатай хэрэглээг дэмжих
- 13 уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- 15 хуурай газрын эко системийг хамгаалах
- 16 энх тайван, шударга ёсыг цогцлоох
- 17 хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх



III. ЗАСАГЛАЛ

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчид ба бүхий л оролцогч талуудын эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд онцгой анхаарч ирсэн.

Бид компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, нүүрсний салбарт улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж үздэг.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (ESG/ БОНЗ)

Компани нь Байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэлийн хэмжилт, хяналт, тайлагналд өндөр ач холбогдол өгөн ажиллаж ирлээ. 2019 онд компанийн ТУЗ-ийн дэргэд Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан, бие даасан хороо байгуулагдсан бөгөөд ингэснээр КНХ, байгаль орчин, засаглалын бодлого, стратеги чиглэл ба гүйцэтгэлүүд жил бүр ТУЗ-ийн түвшинд хянагдан, батлагдаж байна. Мөн КНХ-ын чиглэлд аливаа эрсдэл, алдаа дутагдал үүссэн тохиолдолд ТУЗ-өөс санал зөвлөмж өгөх, ахиц сайжралт гаргах, байнгын эргэх холбоотой хяналт тавих боломж бүрдэж байна.

2022 онд Гүйцэтгэх захирлаар ахлуулсан Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар дагнасан Удирдлагын

Бид дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоодын дүрэм, журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажилладаг.

Компани нь ТУЗ-д үйл ажиллагаагаа шууд тайлагнадаг Дотоод аудитын хэлтэстэйгээс гадна компанийн ерөнхий менежмент, хөрөнгийн удирдлага, шийдвэр гаргалтын үйл явц, тэдгээрийн үр дүнг хянан удирдах чиг үүрэг бүхий Аудитын хороо ТУЗ-ийн дэргэд ажиллаж байна. Одоогоор тус хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн, хараат бус 3 гишүүн ажилладаг.

хороо байгуулагдаж, холбогдох ажил мэргэжил, чиг үүргийн есөн гишүүнтэйгээр ажиллаж эхэлсэн. Улмаар 2023 оноос Хөрөнгө оруулалт, Байгаль орчин, нийгэм, засаглалын албыг шинэчлэн байгуулснаар тус алба нь гол хэмжүүр үзүүлэлтүүд, зорилтууд болон үйл ажиллагааны ба урт хугацааны болзошгүй эрсдлүүд ба шинэ боломжуудыг тодорхойлж, компанийн менежмент, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, компанийн ТУЗ-ийг холбогдох мэдээ, мэдээлэл, чиг үүргээр ханган ажиллаж байна. Ингэснээр компани нь Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлыг компанийн өдөр тутмын үйл ажиллагаа ба урт хугацааны төлөвлөлтөд тусган гүйцэтгэлийн үр өгөөжийг тогтмол сайжруулахад анхаарах боломж, нөхцөл бүрдсэн.

ИЛ ТОД БАЙДАЛ

Бид олон улсын “ISO 26000: Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн бодлого болон Компанийн Нийгмийн Хариуцлагын бодлогоо 2011 онд боловсруулан батлуулж, компанийн бүх салбар болон охин компаниудад танилцуулан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр ирлээ.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон төр засаг, оролцогч талууд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн.

2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр сайн дураараа ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна. Мөн Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА), Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) хамтран санаачилсан “Хариуцлагаар нэгд” аян, “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-д нэгдсэнээр холбогдох үүрэг, амлалтаа бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн холбогдох тайлангууд, шинэ мэдээ мэдээлэл болон ажлын байртай холбоотой бүхий л мэдээллүүд компанийн албан ёсны вэб хуудас (www.energyresources.mn; www.mmc.mn) болон нийгмийн сүлжээний хаягуудаар тогтмол нийтлэгдэж явдаг. Мөн бид оролцогч талууд, орон нутгийн иргэдээс Өргөдөл, гомдол нээлттэй хүлээн авах механизмтай бөгөөд, тухайн жилд хүлээн авсан өргөдөл, санал хүсэлтүүдийн тоо ба хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээллийг холбогдох тайлан, мэдээнд тогтмол тусгадаг.



ҮНЭЛГЭЭ, АУДИТ

2023 онд Энержи Ресурс компанийн хувьд дотоодын болон олон улсын хөндлөнгийн, сайн дурын олон үнэлгээ, аудитад хамрагдаж, өөрсдийн үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийлээ.

TSM

2023 онд бид Канадын уул уурхайн ассоциациас дэлхийн олон улс оронд хэрэгжүүлж, хүлээн зөвшөөрөгдсөн “Towards Sustainable Mining” (TSM) буюу Тогтвортой Уул уурхайн үнэлгээний хөтөлбөрт хамрагдаж, Үйл ажиллагааны өөрийн үнэлгээг Ассоциациас хараат бус байдлаар, бие даан гүйцэтгэж, тайлагнасан анхны олон улсын компани боллоо. Одоогоор бид Өөрийн үнэлгээний эхний шатыг бүрэн хийж дууссан бөгөөд энэ ондоо багтаан TSM-ийн үнэлгээний тайландаа хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэхээр зорьж байна.

TSM нь байгаль орчин, нийгмийн зүгээс ирэх сөрөг нөлөөллийг бууруулахад уул уурхайн компаниудад дэмжлэг үзүүлэх зорилготой, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гүйцэтгэлийн үнэлгээний систем юм. Одоогоор дэлхийн 13 улсын 200 гаруй аж ахуйн нэгж уг хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг хөтөлбөрийн гишүүнээр нэгдэн орсны хувьд бид өндөр чанартай, нотолгоонд суурилсан, өөрийн үнэлгээг хийж, салбарын гүйцэтгэлийг сайжруулахад өөрийн хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

MSCI – БОНЗ үнэлгээ

Morgan Stanley Capital International (MSCI) хөрөнгө оруулалтын фирмийн БОНЗ-ын үнэлгээний систем нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэлхий даяар хөрөнгө оруулагчдын түгээмэл ашигладаг жишиг стандарт юм. Уг үнэлгээ нь компаниудын БОНЗ-ын менежмент, эрсдлийн удирдлагын чанар, гүйцэтгэлд AAA-ээс CCC хүртэлх түвшинд үнэлгээ

хийдэг бөгөөд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтанд БОНЗ-ын эрсдлийг тооцоход чухал үр дүнтэй гэж тооцогддог. Тайлант 2023 онд бид уг систем дэх “А” үнэлгээг хэвээр хадгалж чадлаа.

Хариуцлагатай уул уурхайн кодекс

МУУҮА-ийн “Хариуцлагатай уул уурхай” хөндлөнгийн үнэлгээнд оролцон хараат бус хөндлөнгийн үнэлгээний багт 93.28 хувиар үнэлэгдэж, тайлангаа хүлээн авлаа. Мөн тус ассоциациас хэрэгжүүлдэг “Хариуцлагатай уул уурхайн кодекс”-ийн дагуу хэрэгжилтээ жил бүр өөрсдөө үнэлж, хянаж явдаг бөгөөд тайлант оны хувьд бид үйл ажиллагаагаа 91.6%- иар үнэлж, цаашид засч сайжруулах боломжтой 8.4%-ийн үнэлгээг гаргалаа.

Хүлэмжийн хийн тооцооллын баталгаажуулалт

Тус компани нь 2017 оноос хойш хүлэмжийн хийн ялгарлаа тооцон тайлагнаж буй, Монголын анхдагч компаниудын нэг юм. 2023 онд хүлэмжийн хийн тооцооллын аргачлалаа шинэчлэн, байгууллагын хүлэмжийн хийн тооцооллоо баталгаажуулах зорилгоор Сингапурын SGS компанитай гэрээ байгуулан нэг жилийн хугацаанд хийгдсэн хүлэмжийн хийн тооцооллыг баталгаажуулах аудитыг газар дээрх болон онлайн хосолсон хэлбэрээр зохион байгуулж, сертификатаа хүлээн авав. Компаниас гаргасан хүлэмжийн хийн тооцоолол нь олон улсын ISO 14064-3:2019 стандартын дагуу, WRI/WBCSD Greenhouse Gas (GHG) Protocol-ын шаардлагуудыг хангаж буйг энэхүү үнэлгээгээр баталгаажуулаад байна.

Цаашид энэхүү аудитыг жил бүр тогтмол хөндлөнгийн байгууллагаар хийлгэж улмаар үр дүнд үндэслэн хүлэмжийн хийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Statement SG24/00000018GHG

The inventory of Greenhouse Gas emissions in year 2023 of

MONGOLIAN MINING CORPORATION

16F, Central Tower, Sukhbaatar District Ulaanbaatar 14200, Mongolia

has been verified in accordance with ISO 14064-3:2019 as meeting the requirements of

WRI/WBCSD Greenhouse Gas (GHG) Protocol

Scope 1 GHG Emissions
1,168,554.35 tonnes of CO₂e
Scope 2 and 3 GHG Emissions
29,561,464.43 tonnes of CO₂e
Scope 1, 2 and 3 GHG Emissions
30,730,018.78 tonnes of CO₂e

Authorized by
Susan Law
Susan Law
SEAP Regional Manager
Date: 20 March 2024

Version 1.0

SGS International Certification Services Singapore Pte Ltd
30, Boon Lay Way
#03-01, Singapore 609557

This Statement is not valid without the full verification scope, objectives, criteria and findings available on pages 2 to 6 of this Statement.

Page 1 of 6

ЁС ЗҮЙ, ХҮНИЙ ЭРХ

Бид хүний эрхийн үндсэн зарчмуудыг байгууллагын соёлын үндсэн хэсэг болгон төлөвшүүлснээс гадна үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хийж, хөтөлбөр боловсруулан ажилладаг. Тухайлбал, Ухаа худаг төслийн хүрээнд шинээр ажилд орсон ажилтнуудад Ёсзүйн код, хүний эрхийн журмыг заавал танилцуулахаас гадна жил бүр бүх ажиллагсдыг хүний эрхийн сургалтад давтан хамруулдаг.

Компанийн Ёсзүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад удирдамж, зааварчилгаа болдог. Бид аливаа үйл ажиллагаа, байгууламжид насанд хүрээгүй хүүхдийг албадан хөдөлмөрлүүлэх эсвэл хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгт ашиглахыг тэвчихгүй. Тус компани нь 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийг чанд мөрдөхөөс гадна 1990, 2002 онд соёрхон баталсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2002 онд соёрхон баталсан Насны доод хэмжээг тогтоох тухай конвенц зэрэг холбогдох бусад баримт бичиг, хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажилладаг.

АВИЛГААС АНГИД БАЙХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компанийн дүрэм, журам нь авилга хээл хахуулаас ангид байж, шийдвэр гаргахад албан тушаалтанд нөлөөлөх, давуу байдал бий болгох, шан харамж олгохоос зайлсхийх, бүх төрлийн бизнесийн харилцаанд авилга, хээл хахууль авахыг хориглосон байдаг. Энэхүү шаардлага нь манай үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын ажиллагсдад мөн хамаарна. Бид бүхий л оролцогч талуудтайгаа нягт хамтран ажиллах замаар авлигын эсрэг хатуу зарчим, нийгмийн хариуцлагатай, ханган нийлүүлэлтийн шилдэг туршлагыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

Манай худалдан авалт болон үйл ажиллагааны практик нь шударга бус бизнесийн хэлцэл, сэжигтэй төлбөр болон терроризм, мөнгө угаахтай холбоотой санхүүжилтийг эрс хориглодог. Бид Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг даган мөрдсөөр ирсэн.

IV. БАЙГАЛЬ ОРЧИН

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн бүхий л үе шатанд байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, олон улсын стандартуудыг даган мөрдөж, үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Бид үйл ажиллагаагаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Эрүүл ахуйн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай зэрэг Монгол Улсын 30 орчим хуулиуд болон бусад холбогдох 200 гаруй хууль тогтоомж, журам заавар, стандартын дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

Түүнчлэн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н бодлогын хүрээнд олон улсын ISO 14001:2015 “Байгаль орчны менежментийн тогтолцоо”, ISO 45001:2018 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” болон ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн менежментийн тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л

төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг. Бид нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг гол бүтээн байгуулалтууддаа говийн нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй, ус хамгийн бага ашиглах технологийг ашигладаг.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөг жил бүр боловсруулан, төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасны төлөвлөгөөний биелэлт нь 90%-иас дээш байх шаардлагатай байдаг.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ЗДТГ, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Цогтцэций сумын Уул уурхай-ус хариуцсан байгаль хамгаалагч, Орон нутаг хариуцсан байгаль хамгаалагч, сумын багийн дарга нар болон сумын иргэний төлөөллийн бүрэлдэхүүнтэй комисс компанийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг 93%-тай гэж дүгнэсэн.

Компани говь нутагт ногоон байгууламж, таримал ойн санг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оноос хойш нийт 240,000 гаруй мод тарьж ургуулснаас, 2023 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 60,000 гаруй мод сөөгний суулгац тарьсан бөгөөд **НИЙТ МОДНЫ АМЬДРАЛТЫН ХУВЬ 85%-ИАС ДЭЭШ** байна.



248 мянга
(2010-2023)

Нийт ургуулсан мод, сөөг

62 га
(2020-2023)

Техникийн нөхөн сэргээлт

1.2 сая м³
(2022: 0.7 сая м³)

Дахин ашигласан усны хэмжээ

НӨХӨН СЭРГЭЭЛТ

Газрыг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээж улмаар ирээдүйд бэлчээр болон бусад байдлаар ашиглах боломжтой болгож үлдээх нь хариуцлагатай уул уурхайн нэн чухал хэсэг юм. Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд барих зорилго тавин ажилладаг бөгөөд жил бүр нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. 2020-2023 онд нөхөн сэргээлтийн хүрээнд уурхайн хаягдлын овоолгын 62 га талбайг налуулж, хэлбэршүүлэн үндэсний стандартад нийцүүлэн техникийн нөхөн сэргээлт хийсэн ба 40 га талбайг шимт хөрсөөр хучих, гурван га талбайг ургамалжуулах ажлыг гүйцэтгэн, биологийн нөхөн сэргээлт хийсэн.

УС ХАНГАМЖИЙН МЕНЕЖМЕНТ

Ухаа худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг. Монгол Улсын Усны тухай хууль, MNS 4943:2015 үндэсний стандартыг мөрдөхөөс гадна Олон Улсын Санхүүгийн Корпорацийн санаачилга болох “Өмнийн говийн усны менежементийн Сайн дурын кодекс”-ын гишүүнээр элсэж, гарын үсэг зуран нэгдсэн бөгөөд усны хэмнэлт, дахин ашиглалтын мэдээллээ сайн дураар тайлагнадаг.

Говь нутгийн ус нь эрдэсжилт, хатуулаг ихтэй учраас ундны усанд тогтмол хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Иймд Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангасаар ирсэн. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашиглаж байна.

Бид уурхайн талбайд гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг.

- Ус уурших, шүүрэхээс бүрэн хамгаалагдсан, 56,000 м3 ус агуулах хоёр ширхэг усан сан нь усны ууршилт, нэвчилтийг бүрэн хязгаарласан дэвшилтэт

Дүйцүүлэн хамгаалах ажил

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон нийт 8,000 га талбайг нөхөн сэргээх “Нөхөн сэргээлт 2024” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан. Энэхүү зорилгод манай компани нэгдэж, 2023 онд гар аргаар алт олборлолтын улмаас эвдэрэлд орсон, Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян цагааны нуруунд таван га талбайд техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийснээр зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулж хүн, мал амьтан унаж бэртэх, осол эрсдлийг бууруулж байна.

- технологийн шийдэлтэй.
- Ухаа худагийн цахилгаан станц нь ердийн цахилгаан станцуудаас 4-5 дахин бага ус ашиглах технологитой.
- Тайлант онд цахилгаан станцын концентрацитай ус 51,349 м3 усыг дахин ашигласан байна. Мөн гадаргын түр зуурын урсацын усыг зориулалтын цөөрөмд цуглуулж, уурхайн талбайд төрөл бүрийн зориулалтаар ашигладаг.
- 180,700 мян м3 ахуйн бохир усыг цэвэршүүлж, мод услах, уурхайн тоос дарах зэрэгт ашигласан.
- Малчдын худгийн усны түвшин, уурхайн орчмын цооног болон ус олборлох талбайн усны түвшний хэмжээг сар бүр хянаж, хэмжилт хийсэн.

Түүнчлэн Нүүрс баяжуулах үйлдвэрийнхээ дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг ажиллуулж, хаягдал лагаас усыг шавхаж авах замаар усны дахин ашиглалтыг 95%-д хүргээд байгаа билээ. **Тайлант онд нийт 1,17 сая м3 усыг Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрээс татан авч, дахин ашигласан байна. Мөн 73.7 мянган м3 үерийн усыг зориулалтын цөөрөмд хуримтлуулж, уурхайн төрөл бүрийн хэрэгцээнд ашиглалаа.**

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан нийт ажилчдад “Усны зөв хэрэглээ, ашиглалт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын устгал (2021-2023)

	2021	2022	2023
Аюулгүй хог хаягдал (м³)	9,448	9,253	37,397
Хогийн цэгт хүргэсэн	47.9%	75.1%	97.3%
Дахин боловсруулсан	26.5%	4.3%	0.4%
Шатаасан	16.3%	9.1%	0.0%
Хадгалсан	9.3%	11.5%	2.4%
Эрчим (м³/ROMt)	0.0022	0.0016	0.0026

Ухаа худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг ангилах, дахин ангилах, хог үүсэлтийн хэмжээг бууруулах, дахин боловсруулах талд нийлүүлэх зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, хяналт шинжилгээ тогтмол хийдэг. Мөн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

2023 онд уурхайн талбайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хатуу хог хаягдлын нийт хэмжээ 12,350 м3 байснаас 14%-г дахин боловсруулах боломжтой бөгөөд 5.1%-ийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байна. Төслийн үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдлыг хог хаягдлын цуглуулалт, тээвэр устгалын эрх бүхий “Паблик сервис” компанитай гэрээ байгуулан, тээвэрлүүлж, устгуулдаг.

Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 18 удаа зохион байгуулж, нийт 13 м3 хог хаягдлыг зайлуулсан байна. Түүнчлэн Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 2-8 дахь километрийн хооронд 2023

оны наймдугаар сард хийгдсэн бүх нийтийн хог цэвэрлэгээнд оролцон хуримтлагдсан хур хогийг цуглуулж овоолго үүсгэх болон ачилт хийх ажлыг гүйцэтгэн, 46 машин буюу 1,150 м3 орчим хогны ачилт хийв.

2023 онд нийт 98.6 м3 хаягдал модыг татан авснаас 23 м3 -ийг орон нутгийн иргэдийн ахуйн хэрэглээнд, мөн 110 тонн хаягдал төмрийг хогийн цэгт хадгалж байгаа ба 15 тонн төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг “Хүрэл эрчим” компанид хүлээлгэн өгсөн байна. Мөн 5,400 ширхэг дугуй, 27 тэвш мод, 125 тонн төмөр төвлөрүүлсэн ба компанийн ажичид болон орон нутгийн иргэдэд олгох зохицуулалтын дагуу түгээв.

Аюултай хог хаягдал

Ухаа худаг төслийн хүнд машин механизмын засварын төвд ашиглагддаг нэг тонны савлагаатай тосыг “Майнс Ап” компаниас худалдан авдаг бөгөөд гэрээнд тусгасны дагуу ашигласан тосны саваа тус компанид буцаан нийлүүлдэг. 2023 оны байдлаар 579 ширхэг аюултай хог хаягдал болох нэг тонны тосны савыг нийлүүлэгч болох “Майнс Ап” компанид буцаан ачуулсан байна.

Төслийн хэмжээнд энэ онд 365 тонн хаягдал тос гарсан ба засварын төвд суурилуулсан 50 тонн багтаамжтай зориулалтын ёмкостонд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Хай Би Ойл” компанид нийлүүллээ. 2023 онд аюултай хог хаягдлыг хүлээн авах эрх бүхий “Хай Би Ойл”, “Монпити Ойл” компаниудтай гэрээ байгуулж хамтарч ажиллаж байна. Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал аккумуляторыг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж хүдэр” компанитай 2023 онд гэрээлсний дагуу нийт 427 ширхэг хаягдал аккумуляторыг тус компанид нийлүүллээ.

АГААРЫН ЧАНАР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон агаар бохирдуулагч хийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлдэг. Ухаа худаг уурхайн хүрээнд дуу, шуугианы эх үүсвэр, түвшнийг тогтмол үнэлж хянадаг. Мөн тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор тоосны хэмжилтийг Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хадан дахь тодорхой цэгүүдэд тогтмол хийсээр ирсэн. Тайлант хугацаанд нийт 13 цэгт MNS 4585:2016 стандартын

ЭРЧИМ ХҮЧ, УСНЫ ХЭМНЭЛТ

Байгалийн нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглах нь байгаль орчны тогтвортой байдалд чухал ач холбогдолтой гэдгийг бид хүлээн зөвшөөрч эрчим хүч, усны хэрэглээг багасгах чиглэлд анхаарч ажилладаг. Ус, эрчим хүч, түүхий эд зэрэг нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглахдаа Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудыг удирдлага болгон ажиллаж байна. Үүний дагуу компани нь эрчим хүч, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглахад чиглэсэн нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг батласан.

Бид үйл ажиллагаандаа гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг бөгөөд ус хэмнэх технологиор дамжуулан усны оновчтой үр ашгийг хангахыг зорьдог. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг тогтмол хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашигладаг.

Ухаа худагийн цахилгаан станц нь эрчим хүчний

НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ	2021	2022	2023
I. Усны хэрэглээ (литр/ром.тонн)	204	201	207
II. Дахин ашигласан усны хэмжээ (литр/ром.тонн)	207	111	106

дагуу PM2.5-ын түвшний хэмжилтийг 100 гаруй удаа хийжээ.

Шинжилгээний үр дүнгээр азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад шатахуун түгээх станц дээр хүхэрлэг хий (SO₂) 213.01 мгг/м³-ээр хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол бусад хэсэгт стандартаас давсан үзүүлэлт ажиглагдаагүй байна.

хэмнэлтийг үе шаттайгаар сайжруулахад чиглэсэн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг. Мөн бид талбайнхаа үйл ажиллагааны бүх түвшинд эрчим хүчний хэмнэлттэй холбоотой практик арга хэмжээ, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, зуухны агрегатыг эдийн засгийн үр ашигтай горимоор ажиллуулахын тулд горимын картыг боловсруулж тогтмол хянасны үр дүнд цахилгаан станцын жишмэл түлшийг 2022 онд 730.62 гр/кВт.ц байсныг 2023 онд 728.82 гр/кВт.ц болгож бууруулжээ. Станц нь халаалтын улиралд цахилгаан халаагуурууд ашигладаг бөгөөд цахилгаан халаагууруудын халаалтын улиралд ажиллах горимын картыг батлуулснаар 6,402 кВт.ц ЦЭХ буюу 1.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлснээр 2023 онд 85,758 кВт.ц цахилгаан станцын жишмэл түлшийг хэмнэж, нүүрсхүчлийн хийг 952 орчим тонноор бууруулсан байна.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр ажилласнаар 1,147,419 м³, цахилгаан станцын концентрацитай ус 51,349 м³ усыг тус тус дахин ашигласан байна.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Уур амьсгалын өөрчлөлт, нүүрсхүчлийн хийн ялгарлын эсрэг дэлхий нийтийн хүчин чармайлт эрчимжиж байгаа энэ үед уул уурхайн компаниуд эдгээр ялгаруулалтыг бууруулах төрөл бүрийн арга, технологи дээр илүү шаргуу ажиллаж байна. Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэргийн агаарт агуулагдах хэмжээг бид агаарын чанарын үндэсний стандарт MNS 4585:2016 стандартын дагуу "Ногоон титэм" компаниар Ухаа худаг дахь мониторингийн цэгүүд дээрээс сорьц авахуулж, шинжлүүлдэг.


Бид 2017 оноос эхлэн компанийн үйл ажиллагааны явцад үүсч байгаа хүлэмжийн хийн ялгарлыг хянах зорилгоор ялгарч буй хүлэмжийн хийн тооцооллыг хийж, нээлттэй тайлагнаж эхэлсэн. Анх Түвшин 1 ба Түвшин 2-ын хүрээнд тооцооллыг хийж байсан бол 2019 оноос Түвшин 3-ын хүрээнд нийт 6 үзүүлэлтээр

тооцооллыг гарган тайлагнаж байна. Мөн 2023 оноос тооцооллыг илүү нарийвчилж, нийт гаргасан тооцооллын үзүүлэлтүүдийг олон улсын хөндлөнгийн баталгаажуулалтанд хамруулж эхэлсэн билээ. Цаашид бид 2023 оны үзүүлэлтүүдийг суурь болгон ашиглаж, тооцооллын цар хүрээ, нарийвчлалд улам бүр бодитой сайжруулалт хийхийг зорьж байна.

Уг ажлын хүрээнд хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон цахилгаан станцаас ялгарч буй хүлэмжийн хийн агуулгыг WRI/WBCSD хүлэмжийн хийн протоколийн дагуу тооцоолж байна. Мөн хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг тогтмол төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд цахилгаан станцаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах үүднээс утаа шүүгчийн бүрэн ажиллагааг хангах, горимын тохиргоог хийх, жил бүр ногоон байгууламжийг өргөтгөж мод тарих гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ	2021	2022	2023
I. Түвшин 1	179,496	631,679	1,168,554
II. Түвшин 2	80,613	2,753	16,816
III. Түвшин 3	260,647	12,590,527	29,544,648
IV. Нийт үйлдвэрлэл (CO ₂ e тн)	520,756	13,224,959	30,730,019
V. (CO ₂ e тн) Эрчим	0.108 t CO ₂	3.10 t CO ₂	2.11 t CO ₂

2023 онд хүлэмжийн хий тооцооллын хамрах хүрээг өргөтгөн Баруун наран уурхай, Цагаан хадны хэсгийг хамруулж хүлэмжийн хийг тооцоолон мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажиллаж байна.





ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бид мод тарьж ургуулах урт хугацааны төлөвлөлтийн дагуу говь цөлийн бүсэд хамгаалалтын ойн зурвас байгуулах замаар газар нутгийг хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалах, ойжуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, тус ажлыг шинжлэх ухааны зохих аргачлалд тулгуурлан ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Уг үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлсэн 2021 оноос хойш нийт 153,000 модыг тарьж ургуулаад байна. Байрлалын хувьд компанийн 2011 онд байгуулсан ойн зурвасын хойд талд 40 га талбайг хамрах бөгөөд 2022 оны намрын тарилтаар сумын хэмжээнд нийт 93,000 мод тарих ажлыг зохион байгуулав.

2023 оны хувьд мод тарьж ургуулах урт хугацааны төлөвлөлтийн дагуу Баяндалай

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яам болон аймгаас орон нутгаас өгсөн чиглэлийн дагуу, Өмнөговь аймгийн Баяндалай сумын 20 га талбайд 20,000 заг тарин бойжуулахаар болсон. Үүний дагуу, 2023 оны намар **ЗАГ МОДНЫ ЭХНИЙ 10,000 СУУЛГАЦЫГ 10 ГА ТАЛБАЙД** мэргэжлийн байгууллагатай хамтран амжилттай тарив. Цаашид тарьсан суулгацуудын арчилгаа, бойжилгоонд анхааран ажиллаж байна.

сумын Цагааны голд байгалийн урсац бүхий булгийг түшиглэн Өмнөговь аймгийн БОАЖГ-аас санал болгосон 10 га талбайд загаар ойжуулалт хийх ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн. Мөн ажилчдын хотхон болон ажилчдын орон сууц орчмын нийтийн эзэмшлийн талбайд 29,000 мод, Богд уулын Хүрхрээгийн аманд 2,500 мод, Хэнтий аймгийн Мөрөн сумын тариалангийн талбайн хамгаалалтын зурваст 9,000 мод тус тус тарьснаар тайлант онд нийтдээ 50,500 мод тарьжээ.

Цагаанхад НАБТ-н ажилчдын хотхонд хоногт 100 м3 ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж байгуулж, ашиглалтад оруулсан бөгөөд тус цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг мод усалгаанд ашиглахаар төлөвлөж байна.



МОД ҮРЖҮҮЛЭГ

Бид компанийн байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилт, мод үржүүлгийн талбайд говийн бүс нутагт дасан зохицсон, амьдрах чадвар өндөртэй мод сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлын суулгацыг бэлтгэн биологийн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах зэрэг үйл ажиллагаанд 2010 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд жилд дунджаар 5-10 мянга орчим мод сөөг, бутлаг ургамлын тарьц, суулгац үржүүлж бойжуулдаг. 2023 оны хавар талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхлүүлж тоорой, жигд, сухай, заг, улиас, агч, бүйлс гэх мэт **10 ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН 10,000 ШИРХЭГ ҮР БОЛОН МӨЧРӨӨР ТАРЬЖ УРГУУЛАН АРЧИЛГАА ХАМГААЛАЛТЫГ ХИЙЛЭЭ.** Тоорой модыг үрээр тарималжуулан ургуулах туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлэн Баянхонгор аймгийн Эхийн голоос тоорой модны үр түүж, мод үржүүлэг туршилтын талбайд тарьж байна.



АМЬТНЫ АЙМГИЙН СУДАЛГАА




БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ

Бид 2009 оноос хойш Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг төдөвлөгөөний дагуу жил бүр хийж ирсэн бөгөөд 2023 онд Цогтцэций сумын зүүн талд байрлах Хангинах, Тугийн цохио зэрэг байршлуудад нийт 40 боодол өвс байршуулсан. Өвс тавих байршлыг Цогтцэций сумын байгаль хамгаалагч болон нутгийн малчин өрхөөс өгсөн зөвлөмжийн дагуу тодорхойлсон болно. Ийнхүү зэрлэг амьтдад зориудаар ус, өвс тэжээл тавьж байгаа нь хавар, өвлийн хохирол цагт тэдгээр амьтдыг идэш тэжээлийн хомсдолд орох, харангадаж эрсдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Мөн зэрлэг амьтдын ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулан, амьтны мониторинг хийж байна. Цагаан хадны Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд 2019 онд байгуулсан уст цэгийг тогтмол усаар хангаж, уст цэгийн ойролцоо автомат камер байрлуулж биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Бид жил бүр амьтны аймгийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг бөгөөд 2023 онд Цогтцэций сумын баруун хойно байрлах Таван толгойн нисэх буудлын орчим жижиг хөхтөн амьтан болон шувуудын нарийвчилсан судалгаа, Ойн зурвас орчим шувуудын төрөл зүйлийн бүрдэл, тоо толгойг тогтоох судалгаа, Наймдайн хөндий орчимд жижиг хөхтөн амьтны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн.

Судалгаагаар Таван толгойн нисэх буудлын орчимд гурван зүйл жижиг хөхтөн амьтан бүртгэсэн. Таван толгой нисэх буудал орчмын шувуудын төрөл зүйлийн судалгааг өмнөх оныхтой харьцуулж дүгнэхэд зүйлийн олон янз байдал нэмэгдсэн хэдий ч бодгалийн тоо эрс буурсан байна. Ойн зурваст бүртгэгдээд буй 47 зүйл шувуудыг экологийн статус буюу оршин амьдрах хэлбэрээр нь авч үзвэл 31 зүйл буюу 65 хувь нь нүүдлийн буюу хагас нүүдлийн, 15 зүйл буюу 35 хувь нь суурин тохиолдсон. Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуур үнэлгээгээр (IUCN) Олон улсын хэмжээнд "Ховордож болзошгүй" гэж үнэлэгдсэн нөмрөг тас байгаа бол бусад 46 зүйл нь бүс нутгийн болоод олон улсын хэмжээнд "Анхааралд өртөхөөргүй" буюу тоо толгойн хувьд тогтвортой, түгээмэл тохиолдох зүйлүүд байгааг тогтоосон.

Наймдайн хөндийд 2022 онд хийсэн жижиг хөхтөн амьтны судалгаагаар хоёр зүйлийн 22 бодгалийг ажиглах буюу барьж байсан бол энэ жил дөрвөн зүйлийн 32 амьтан барих буюу бүртгэсэн нь **ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ИНДЕКС 0.1 БАЛЛААР ӨНДӨР БАЙГААГ** илтгэж байна.



ИРГЭДИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТ МОНИТОРИЙГ

Ухаа худаг уурхайн Байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд хамтран байгаль орчны хээрийн хэмжилтийн ажилд иргэдийг оролцуулж хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд олгох зорилгоор уг ажлыг жил бүр зохион байгуулдаг. Энэ жилийн мониторингийн ажилд худаг ашигладаг орон нутгийн иргэдийг түлхүү хамрууллаа.

V. АЖИЛЛАГСАД

 **2,372**
(2022: 1,979)

Нийт үндсэн ажиллагсдын тоо

 **13%**
(2022: 15%)

Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь

 **146** тэрбум
(2022: 96 тэрбум)

Цалин, урамшуулалын зардал

 **1,108**
(2022: 761)

Шинээр бий болгосон ажлын байр

Энержи Ресурс компани нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 60 гаруй хууль журмыг мөрдөн ажиллахаас гадна Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг чанд дагаж биелүүлдэг.

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны аливаа дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрддөг.

Компанийн зүгээс ажлын байрыг нээлттэй, ил тод, шударгаар зарлаж хөдөлмөрийн зах зээл дээрээс хүний нөөцийн бүрдүүлэлт үүсгэн ажилладаг. 2023 оны 12-р сарын эцсийн байдлаар тус компани нийт 2,372 үндсэн ажиллагсадтай ба түүний 35%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Баян-Овоо, Ханхонгор сумын иргэд зонхилон бүрдүүлж байна. Түүнчлэн Ухаа худаг цогцолборын хүрээнд шууд ба шууд бусаар нийт 7,200 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.

2023 онд 1,108 ажлын байр шинээр бий болгож, зайнаас ажиллах уян хатан бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Тухайлбал, 6-аас доош насны хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг долоон хоногийн ажлын дөрвөн өдөр оффисоос, нэг өдөр гэрээс ажиллуулах, оффисын нийт ажиллагсдын ажлын цагийг өглөө 08-10, орой 17-19 буюу уян хатан ирүүлэх гэх мэт зохицуулалтуудыг хэвээр үргэлжлүүлж байна.

ҮНДСЭН АЖИЛЛАГСАД



ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЗАРЧИМ, ТЭГШ БОЛОМЖ

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг нэн тэргүүнд дээдэлж, бүх ажиллагсдыг ижил тэгш боломжоор хангахыг зорьдог. Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харъяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон дэв зэргээс хамаардаг.

2023 онд нийт ажиллагсдын ойролцоогоор 13%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд **УДИРДАХ ТҮВШНИЙ АЖИЛТНУУДЫН 30% НЬ ЭМЭГТЭЙЧҮҮД** байгаа нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт

юм. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. Орон нутагт ээлжээр ажилладаг эмэгтэй ажиллагсдын байр, орон сууцны нөхцлийг сайжруулах ажлууд байнга хийгдэж ирсэн. Ажиллагсдыг насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 62%-ийг 30-50 хүртэлх насныхан, 32%-ийг 30 хүртэлх насныхан бүрдүүлж байна.

2023 онд нийт 26 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж тогтмол орлоготой байхад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг цаг тухай бүр нь төлж, хуулийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж байна.

Ажлын байр, тэгш боломж

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022	2023
I. 30 хүртэлх насны ажиллагсад	26%	31%	32%
II. 30-50 хүртэлх насны ажиллагсад	68%	62%	62%
III. 50-с дээш насны ажиллагсад	6%	7%	6%
IV. Эмэгтэй ажиллагсад	14%	15%	13%
V. Удирдах түвшний эмэгтэй ажиллагсад	33%	31%	30%
VI. Удирдах зөвлөл дэх эмэгтэйчүүд	12%	12%	12%
VII. Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад	4%	4%	1%

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн хангамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Ажилтнуудаа орон сууц, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, бизнес эрхлэх, тав тухтай шилжин суурьшиж, "хөлөө олох"-од нь туслах, ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр нийгмийн асуудалд нь нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн. 2023 онд нийт ажиллагсдын нийгмийн даатгал, цалин урамшуулалд 146 тэрбум төгрөг олгосон байна.

Мөн "Цэций" орон сууцны хороолол болон "Уурхайчин" гэр хороололд суурьшуулсан ажилтнуудаас тогтвортой ажиллах гэрээний хугацаа нь дууссан 35 ажилтанд орон сууц, 30 ажилтанд хашааны газар эзэмших эрхийг нь тус тус үнэ төлбөргүй шилжүүлсэн. Ажиллагсдаа тогтвор суурьшилтай, гэр бүлтэйгээ хамт тав тухтай ажиллах амьдрах нөхцлийг нь сайжруулах зорилгоор орон сууцны дараагийн төсөл болох "Цэций

2" хорооллын ажлыг эхлүүлсэн.

Түүнчлэн 2023 онд компанидаа олон жил тогтвортой ажилласан ажилтнууддаа ажилласан жилээс нь хамааруулан Тогтвортой ажилласны мөнгөн шагналыг олгож эхэллээ.

Тайлант онд бид шинээр 1,108 хүнийг шинээр ажлын байраар хангасан байна. Хэдийгээр хөдөө орон нутагт чадварлаг, мэргэжлийн боловсон хүчний нөөц туйлын дутмаг байдаг ч ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байдаг нь компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм. Компанийн **НИЙТ АЖИЛТНУУДЫН 43% НЬ ТОГТВОР СУУРШИЛТАЙГААР ДӨРӨВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАЖ БАЙГАА** нь компанийн зүгээс ажилтнуудаа ижил, тэгж боломжоор хангаж ирсний үр дүн юм.

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн орон нутгийн, мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Ур чадварын үнэлгээнээс ажиллагсдын ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудын төрлийг тодорхойлдог.

2023 онд давхардсан тоогоор нийт **11,835 АЖИЛЛАГСДЫГ** ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудад хамруулжээ. Үүнээс 506 хүнийг ерөнхий ур чадварын сургалтанд, 1,005 хүнийг мэргэжлийн сургалтанд, 10,324 хүнийг хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй байдлын сургалтад тус тус хамруулсан байна. Мөн нийт ажилтнуудад аюулгүй ажиллагааны цахим сургалтыг үргэлжлүүлснээс гадна уул уурхайн **ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН ОПЕРАТОРЫН 35 УДААГИЙН СУРГАЛТАНД 144 ХҮНИЙГ ХАМРУУЛЖЭЭ.**

Мөн тайлант хугацаанд үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлтэй буюу тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллах иргэн, ажилтнуудад сургалт зохион байгуулах эрхийн хүрээнд давхардсан тоогоор 2,479 хүнд сургалт зохион байгуулсан.

Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нарийн мэргэжлийн 48 сургагчтай бөгөөд сургагч нарыг тасралтгүй хөгжүүлэх зарчмыг баримтлан ажлын байранд сурч хөгжих бололцоог бүрдүүлэхээс гадна мэргэжил ур чадварыг дээшлүүлэхээр сургалтын байгууллагуудаас таван төрлийн сургалт авч давхардсан тоогоор 43 сургагчийг мэргэшүүлсэн байна.

Хэдийгээр уул уурхай нь эрчүүд давамгайлсан салбар гэгддэг ч компанийн зүгээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байрны тэгш боломжоор хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. 2023 онд 15 эмэгтэйг хүнд машин механизмын оператор мэргэжил олгох сургалтанд хамруулан, ажлын байраар хангажээ.

♀ Сургалтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн үзүүлэлт (2023)

Операторын давтан сургалт	Операторын мэргэжил олгох сургалт
184	15
Нийт суралцагчдын 11%	Нийт суралцагчдын 10%



Баянхонгор аймгийн иргэн С.Анхбаяр:

"Энержи Ресурс компанийн хүнд машин механизмын сургалтад амжилттай хамрагдсаны эцэст Ухаа худаг уурхай дээр ажлын байран дээр гараад уурхайчин залуустайгаа мөр зэрэгцэн явж байгаадаа баяртай байна. Анх сургалтад сууж байхдаа том техникүүдийг хараад их сүрдэж байсан. Хамгийн сонирхолтой нь дадлагын буюу симуляторын сургалт байсан. Одоо онол, практиктаа сайн суралцсан тул цаашид дадлага туршилагаа сайжруулаад ур чадвартай сайн ажилтан болох хүсэл эрмэлзэлтэй байна. Нарийн мэргэшүүлж, зааж сургасан багш нартаа маш их баярлалаа".

VI. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Энержи Ресурс компани нь эрхэм зорилго, үнэт зүйлсийг баримтлан, ажилтанд ээлтэй, эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ажлаа аюул осолгүй гүйцэтгэх боломжийг ханган Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг.

Бид бүхий л үйл ажиллагаандаа олон улсын ISO 45001:2018 стандарт болон Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж байна. ХАБЭА-н мэдээллийн санг ISO 45001:2018 стандартын бүтцийн дагуу бий болгож, өгөгдөл мэдээллийг хуримтлуулан дүн шинжилгээ, тайлан мэдээг боловсруулан ажилладаг. Түүнчлэн ХАБЭА-н менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах, ослыг бууруулах, аюул эрсдлийн хяналтыг сайжруулах зорилгоор бүх журмуудыг гурван жил тутам хянаж, шинэчлэн сайжруулдаг.

ХАБЭА-н хэсэг нь компанийн бүх хэлтэс алба, туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөгөө өгч ажилладаг ба Ухаа худаг уурхай, Баруун наран уурхай, Гашуун сухайт авто зам, Ханбогд сумын Цагаан хад хэсэг, Ганц мод боомтын чингэлэг тээврийн терминалын хэсгүүдэд ХАБЭА-н өдөр тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид Монголын уул уурхайн компаниудаас анх удаа Олон улсын чанарын менежментийн тогтолцооны

ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж, олон улсын стандартын шаардлагыг хангасан компани болсон. Компанийн хэмжээнд осол бууруулах болон аюулгүй ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2023 оны байдлаар 12.5 сая хүн/цаг ажиллан, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдолгүй ажиллаж байна.

Ажилтнууд манай компанийн амин чухал үнэт зүйл гэж бид үздэг тул хөдөлмөр эрхлэх орчинг нэн тэргүүнд анхаардаг. Бидний зорилго бол мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх менежментийг тасралтгүй сайжруулах явдал юм. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хангахыг эрмэлздэг.

Мөн уурхайн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний ач холбогдол өгч “Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая” уриаг эрхэмлэн ажиллаж ирсэн.

SAFETY FIRST

YOUR LIFE DEPENDS ON IT



“0.80”

(2022: 0.43)

Хугацаа алдсан гэмтлийн давтамж



“0”

(2022: 0%)

Мэргэжлээс шалтгаалах өвчлөл

ХАБЭА-Н ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021	2022	2023
I. Нийт ажилласан хүн цаг (сая)	5.9	6.9	12.6
II. Эндэгдэл	2	0	3
III. Нийт гэмтлийн давтамж	1.01	1.59	2.55
IV. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамж (LTIFR)	0.00	0.43	0.80
V. Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	0	0	0
VI. Хууль, журамд нийцэж ажилласан байдал	93%	96.5%	93.4%
VII. ХАБ-ын сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	7,850	12,150	24,724



12.6 сая

(2022: 6.9 сая)

Ажилласан хүн/цаг



93.4%

(2022: 96.5%)

Хяналт шалгалтын үнэлгээнээс авсан дүн

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ

Нийт ажилтныг ажлын байрны сөрөг хүчин зүйлийн өртөлт, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад хууль, эрх зүйн баримт бичиг, олон улсын конвенц, ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийг хангуулж ажилладаг. Цаашид бид Монгол Улсдаа хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн сайн туршлагаар тэргүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдолгүй жишиг уул уурхай болон ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Бид 2023 онд Хөдөлмөрийн эрүүл мэнд, эрүүл ахуйн тогтолцоо, урьдчилсан сэргийлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа илүү сайжруулахаар хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар Хөдөлмөрийн эрүүл ахуйн аудит хийлгэсэн бөгөөд дээд, дунд шатны удирдлага, ХАБЭА, хүний нөөцийн ажилтнуудад Хөдөлмөрийн эрүүл мэндийн менежментийн сургалтыг онлайн болон танхимаар зохион байгуулсан. Уурхайд ашиглагдаж буй 73 хүнд машин механизмд кабины битүүмж сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэв. Засвар хийхийн өмнө болон дараа нь тоос, шуугианы хэмжилт хийж сайруулалтын үр дүнг тооцоход кабины тоосжилт 40-70% буурсан байна.

Компанийн хэмжээнд 2023 оны эхний улиралд алба, хэсгүүдийн ХАБЭА-н соёлын төлөвшлийн түвшинг таван шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн дагуу судалгаа, уулзалт ярилцлага, үзлэг шалгалт, хяналт зэргийг зохион байгуулан харгалзах оноог онооны системийн дагуу өгч таван түвшинд үнэлэхэд **СОЁЛЫН ТӨЛӨВШЛИЙН ТҮВШИН CALCULATIVE БУЮУ 3-Р ТҮВШИНД ҮНЭЛЭГДЛЭЭ.**



СУРГАЛТ ЗААВАРЧИЛГАА

Монгол Улсын хууль тогтоомж, төрийн захиргааны байгууллагын баталсан дүрэм журмын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Сургалтын төв нь есөн төрлийн ХАБЭА-н сургалт зохион байгуулах эрхтэй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн менежмент, өндөр эрсдэлтэй ажлын байр, мэргэжлээс шалтгаалах өвчин, анхны тусламж, эрүүл мэнд, хамгаалах хэрэгсэл, цахилгааны аюулгүй байдал, анхны тусламж гэх мэт 24 төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулан ХАБЭА-н соёлыг ажилтнууддаа түгээж байна. Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч 24,724 хүнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэдлэг, үр чадвар олгох 84,796 хүн/цагийн сургалт зааварчилгаа зохион байгуулсан байна. ХАБЭА-н чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч нарыг мэргэжил үр чадварыг хөгжүүлэхэд компанийн зүгээс бүхий л нөөц боломжоор ханган олон улсын болон дотоодын тэргүүн туршлагыг тухай бүр нэвтрүүлэн ажилласан байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦТЭЙ БАЙДАЛ

Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд уурхайн бүх үйл ажиллагааг хамарсан төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг 2023 онд давхардсан тоогоор 38 хяналтын чиглэлд 2,312 хуулийн шаардлагын хүрээнд хийхэд нийт 316 үл нийцэл илэрч, хууль сахин мөрдөлт 88%, эрсдэл үүсэх магадлал 12%-тай гэж дүгнэгдсэн. Энэ дагуу **20 ҮЛ НИЙЦЭЛ БҮРЭН ЗАЛРУУЛАГДАЖ, 296 ҮЛ НИЙЦЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ЗАЛРУУЛАЛТ ХИЙГДЭЖ** байна. Төрийн эрх бүхий байгууллагууд байгаль орчин, гал гамшиг, нисэх буудлын үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цацраг, геологи, татвар, уул уурхай, хими, ус хангамж, хэмжил зүйн үйл ажиллагааны чиглэлээр тус тус хяналт шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгсөн. Илэрсэн зөрчлийг хуулийн хугацаанд нь бүрэн залруулж албан тоотоор хариуг хүргэж танилцуулж, ажилласан байна.



ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Бид 2023 онд Франц улсын "Afnor group", Монгол Улсын "Moncertf" баталгаажуулалтын байгууллагуудаас гадна БНХАУ-ын тохирлын үнэлгээний хамгийн том байгууллага болох "Beijing United Intelligence Certification (UICC)"-ны **ХӨНДЛӨНГИЙН АУДИТАД АМЖИЛТТАЙ ДҮГНҮҮЛЭН ГУРВАН ОРНЫ ГЭРЧИЛГЭЭГ АВААД БАЙНА.** Уул уурхайн салбарт олон улсын ISO стандарт цогц байдлаар нэвтэрснээр бүтээмж, засаглал, бүтээгдэхүүний чанар гээд бүх талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдөнө. Хамгийн гол нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартуудыг жигд мөрдөж, хариуцлагатай уул уурхай төлөвших чухал ач холбогдолтой юм.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг компанийн хэмжээнд хэрэгжүүлэхдээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөлт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшгийн хор хөнөөлийг арилгах гэсэн цогц байдлаар зохион байгуулан ажилладаг. Энэ хүрээнд Өмнөговь аймгийн ОБГ, Цогтцэций сум дахь ОБХ-ийн ГТУА 44-р ангитай хамтарсан тактикийн сургуулийг ажилчдын амрах хотхон "Галлей кемп"-д амжилттай зохион байгуулсан. Бид онцгой нөхцөл байдал үүссэн үед Цогтцэций сумын ОБХ-тэй хамтарч гамшгийн эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах, шаардлагатай тусламж үйлчилгээг зохион байгуулж ажилласаар ирсэн. Цогтцэций сумын хэмжээнд гарсан гал түймэр, осол аваар, байгалийн аюулт үзэгдэл, гамшгаас хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг авран хамгаалахад тухай бүрд дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг. Ухаа худаг уурхайн хэмжээнд галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галаас хамгаалах нэгдсэн системтэй болох зорилго тавьж эхний ээлжинд зураг төслийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж эхлээд байна.

VII. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ

Энержи Ресурс компанийн хувьд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Энэ утгаараа Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 онд гаргасан “ISO 26000: КНХ-ын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн болон КНХ-ын бодлогоо боловсруулж, үйл ажиллагаандаа тусгаж ирсэн.

Уг бодлогын зорилт нь ирээдүй хойч үеийн хэрэгцээг хангах байгалийн нөөц, боломжийг аль болох доройтуулахгүй байхын зэрэгцээ байгаль орчин, орон нутгийн иргэдэд сөрөг нөлөөллийг ямагт тооцож, хариуцлагатай, урт хугацааны тогтвортой бизнесийн зарчмаар ажиллахад чиглэдэг.

Компанийн зүгээс хийж хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хийж төслийн сонирхогч талууд болон олон нийтэд танилцуулдаг. Энэхүү үнэлгээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжүүлэлтийн явцад эерэг нөлөөллийг дэмжин, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах төлөвлөгөөний дагуу тодорхой шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн.

- Төслийн сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
- Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөө
- Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө
- Өргөдөл гомдол барагдуулах механизм
- Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө
- Олон нийтийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын төлөвлөгөө
- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө

Эдгээр төлөвлөгөөний дагуу хийсэн ажлуудаа хөрөнгө оруулагч болон олон нийтэд тогтмол тайлагнах үүрэг хүлээдэг. Энэ дагуу бид 2008 оноос буюу Ухаа худаг уурхайн үйл ажиллагаа хараахан эхлээгүй байх үеэс эхлэн орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, ил тод хэлэлцэх Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг тогтмол хийж ирсэн.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ нэг удаагийн хандив тусламжаар асуудлыг шийдэх бус, үлдэцтэй, олон хүнд бодитой үр өгөөжөө өгч чадахуйц, урт хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар орон нутгийн цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах үндсэн зарчмыг баримталж ирлээ.



₮ 501 тэрбум
(2022: 347 тэрбум)

Татвар, шимтгэл

7,200
(2022: 5,000)

Шууд ба шууд бус
ажлын байр

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын ТОП 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулсаар ирсэн.

2009 онд үүсэн байгуулагдсан цагаасаа хойш компани нийт нэг 1.5 тэрбум долларыг уурхайн болон дагалдах дэд бүтцийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 2.6 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлсэн байна. 2023 онд

НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

Бид оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай үед мөнгөн болон эд материалын хандив, тусламжийг компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд үзүүлсээр ирсэн. Тайлант онд оролцогч талуудын хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг бэхжүүлэх үүднээс 50 гаруй тэрбум төгрөгийн бэлэн болон бэлэн бус хандив, тусламжийг нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалтад зарцуулжээ.


2023 онд нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйлсэд бодит хувь нэмрээ оруулах төсөл хөтөлбөр болон ивээн тэтгэлгийн хүрээнд “Монголын Тусгай Олимпын хороо”, “Монголын уул уурхайн үндэсний ассоциаци” “Говийн уурхайчид”, “Цэцийн өнгө”, “Монголын Геологийн холбоо”, “Ашигт малтмал баяжуулагчдын

Энержи Ресурс компани нь улсын төсөвт 501 тэрбум төгрөгийг татвар, шимтгэл хэлбэрээр төвлөрүүлэн ажиллажээ.


Бид үйл ажиллагааныхаа хүрээнд дотоодын нийт 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн байна. Зөвхөн 2023 оны байдлаар нийт **450 ГАРУЙ АЖ АХУЙН НЭГЖЭЭС 1.8 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ХЭРЭГЦЭЭТ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВСНЫ 90 ХУВЬ НЬ ДОТООДЫН АЖ АХУЙН НЭГЖ, КОМПАНИУД** байлаа. Мөн тайлант онд бид ажиллагсдынхаа цалин урамшуулалд нийт 146 тэрбум төгрөгийг олгосон байна.

холбоо”, “Уул уурхайн эрдэнэс зөвлөл”, “Залуу судлаачдыг дэмжих сан” зэрэг нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг **20 ГАРУЙ ТББ-УУДАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАСАН** байна. Тухайлбал, Улаанбаатарын утааг бууруулах Засгийн газрын үйл ажиллагааг дэмжин шахмал түлшний үндсэн түүхий эдийг төрийн өмчит “Тавантолгой түлш” компанид үнэ төлбөргүй нийлүүлэх ажлын хүрээнд тайлант онд нийт 38 тэрбум төгрөгийн өртөг бүхий 418 мянган тонн баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлжээ. Мөн 2023 оны Дэлхийн Тусгай Олимпын наадамд Монгол Улсаас 3x3 сагсан бөмбөгийн төрлөөр оролцох тусгай хэрэгцээт хүүхдүүдийн боломж, нөхцлийг нь бүрдүүлж өгсөн бол орон нутгийн хүүхэд залуусыг чөлөөт цагаараа спортоор хичээллэх боломжийг нь бүрдүүлж, Цогтцэций суманд хөл бөмбөгийн зүлэг ногоон талбайг засаж, шинэчлэх ажилд дэмжлэг үзүүллээ.

ТАТВАР ХУРААМЖ



НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ



САГСАН БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГУУДЫН АЛБАН ЁСНЫ ТҮНШ

Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани нь сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр дөрөв дэх жилдээ нэрлэгдэн “Энержи 3x3 сагсан бөмбөгийн клуб” ТББ, “3x3 сагсан бөмбөгийн холбоо”, “Монголын сагсан бөмбөгийн холбоо” зэрэг ТББ-уудтай нягт хамтран ажиллаж байна.

Бид Монголдоо анх удаа “Энержи 3x3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүд болон Олимпын наадамд оролцох бүх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2023 онд мэргэжлийн нийт гурван багийн тамирчин, дасгалжуулагч, арын албаныханд

санхүүгийн болон бэлтгэл, сургуулилт, менежментийн байнгын дэмжлэгийг үзүүлэн ажиллажээ.

Тайлант онд FIBA 3x3-ийн World Tour, Challenger, Women’s Series, Super Quest зэрэг олон улсын тэмцээнүүдэд амжилттай оролцож, “Ulaanbaatar MMC Energy” баг нь чансаагаараа дэлхийн шилдэг 10 багийн нэгт шалгарсан бодит үр дүн үзүүлсэн төдийгүй, FIBA 3x3-ийн Shanghai World Tour зэрэг тэмцээнд түрүүлж Монголын баг анх удаа хамгийн өндөр чансаатай их дуулга тэмцээний аварга болсон өндөр амжилт үзүүлсэн юм. Мөн Монголын 5x5 сагсан бөмбөгийн Үндэсний лиг, Сагсан бөмбөгийн Азийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шатны тэмцээнүүдийг эх орондоо амжилттай зохион байгуулахад албан ёсоор түншилж, оролцогч талуудын тэгш хөгжлийг бий болгоход дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

“Ulaanbaatar MMC Energy” мэргэжлийн багийн тамирчин Д.Дэлгэрням

“Миний хувьд сагсан бөмбөгийн спортоор хичээллээд 16 жил болж байгаа ахмад тоглогчдын нэг юм. Сагсан бөмбөгийн спорт, ер нь багийн спорт нь өнөөгийн монгол залуучуудын дунд заавал хөгжих ёстой гэж боддог. Учир нь бид олуулаа хамтарч, нэг зүйлийн төлөө хамтдаа зорьж, багаар ажиллаж сурснаар ирээдүйд хөгжих, эв нэгдэлтэй байх хамгийн том хүмүүжил, төлөвшилийг олж авах ач холбогдолтой гэж үздэг.

Өнөөдөр сагсан бөмбөгийн 3x3 төрлөөр монгол залуус олон улсын тавцанд, олон улс үндэстний залуустай энэ тэнцүү өрсөлдөж чадаж байгаа нь бидэнд боломж байгааг харуулж байна. Орчин цагийн залууст зөвхөн Монголдоо өрсөлдөх биш олон улсын тавцанд өрсөлдөх боломжтой юм иүү гэдэг мөрөөдөл боломжийг харуулж өгөхийг зориж, монгол залуусаа бүх нөхцлөөр нь дэмжин ажиллаж байгаа Энержи Ресурс компанидаа баярлаж явдаг”



VIII. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

₮ 25.3 тэрбум
(2022: 21.3 тэрбум)

Орон нутгийн хөрөнгө оруулалт

₮ 14.1 тэрбум
(2022: 14.3 тэрбум)

Орон нутгийн худалдан авалт

4.7 тэрбум
(2022: 1.3 тэрбум)

Орон нутгийн хандив тусламж

35%
(2022: 39%)

Орон нутгийн ажиллагсад

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бид үүсэн байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр хамгийн багадаа нэг тэрбум гаруй төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсаар ирсэн.

Энержи Ресурс компани нь төслийн үйл ажиллагаандаа оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн урт хугацаанд тогтвортойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах зарчмуудыг ханган ажилладаг.

- Иргэд, олон нийтийг компанийн үйл ажиллагааны талаар холбогдох мэдээлэл авах эрхийг бүхий л талаар ханган ажиллах;
- Олон нийтийн иргэдийн санал хүсэлтийг “Нээлттэй өдөрлөг” хийх замаар үйл ажиллагаандаа тогтмол тусгах;
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар төрөл бүрийн хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, сайн дурын зөвлөлийг дэмжин ажиллах;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Иргэдийн санал, хүсэлт болон өргөдөл гомдлыг мэдээллийн төв болон бусад сувгаар тогтмол хүлээн авах.

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөлийг байгуулан тууштай хамтран ажилласаар ирсэн.

Бид оролцогч талуудтайгаа орон нутгийн мэдээллийн төв болон бусад сувгаар дамжуулан харилцаж иргэдийн ажилд орох хүсэлтийг хүлээн авахаас гадна тогтмол хугацаанд нөлөөллийн бүсийн иргэдтэй биечлэн уулзаж, малчдын гэрээр орж санал, гомдлыг нь сонсдог.

Түүнчлэн орон нутгийн иргэдийг байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг.



ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Бид орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа дэд бүтэц, иргэдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьж ажилласаар ирсэн.

Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дүгээр заалт болон Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан загвар гэрээний хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон Энержи Ресурс компани хооронд хамтын ажиллагааны гэрээг 2017 онд байгуулсан юм.

Хамтын ажиллагааны гэрээний дагуу орон нутгийн

онцлог, хөгжлийн бодлоготой уялдуулан олон нийтэд хүртээмжтэй, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ажлыг оролцогч талуудтайгаа хамтран үр дүнтэй хэрэгжүүлэх зарчмыг баримталсан. Ийнхүү орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих урт хугацааны хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоотойгоор арав гаруй жил үр дүнтэйгээр хэрэгжүүлж байгаа нь энэхүү гэрээний үндсэн зарчим бөгөөд хэрэгжилт, үр дүнг жил тутам Өмнөговь аймгийн Засаг дарга болон Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнаж, ОУИТБС-ын тайланд тусгасаар ирсэн.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Орон нутгийн иргэд болон ажиллагсаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэн эргэн мэдээлэх “Иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2023 онд нийт **65 ХҮСЭЛТ, НЭГ ГОМДОЛ ХҮЛЭЭН АВЧ, ХҮСЭЛТҮҮДЭД 100 ХУВЬ ХАРИУ ӨГӨН, ШИЙДВЭРЛЭЖЭЭ.** Нийт хүлээн авсан өргөдлүүдээс

санхүүгийн дэмжлэг хүссэн долоон өргөдөлд татгалзсан хариу өгсөн. Өргөдлүүдэд компаниас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сургалтад хамрагдах, хамтран ажиллах мөн санхүүгийн болон биет дэмжлэг хүссэн, утгатай хүсэлтүүд зонхилж байсан. Тухайлбал, сүүлийн жилүүдэд сумын хүн амын төвлөрөл ихсэж шилжин суурьшил нэмэгдэж байгаатай холбоотой орон сууц, хувийн байшин барилга ашиглалтанд ихээр орох болсон тул цэвэрлэх байгууламжид орон нутгийн иргэд болон аж ахуй нэгжүүд ахуйн бохир усаа нийлүүлэх гэрээ хийх хүсэлтүүд нийт өргөдлүүдийн хамгийн их буюу 24 хувийг эзэлж байна. Мөн

ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛ

Орон нутгийн иргэдтэй нээлтэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс 2011 оноос хойш Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций сумдад 9-11 хүний бүрэлдэхүүнтэй, Орон нутгийн сайн дурын зөвлөл ажилласаар ирсэн. Зөвлөлийн гишүүд нь компанийн төлөөлөлтэй хамгийн ойр, тогтмол хугацаанд уулзаж, нутгийн иргэдийн санал зөвлөмжийг уламжилж, компани болон иргэдийн хооронд нээлтэй, эрх тэгш оролцоог хангах, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

компаниас хэрэгжүүлдэг орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 16 иргэний өргөдлийг 100 хувь шийдвэрлэжээ. Нэг гомдлын тухайд Цагаан-Овоо багийн малчин С.Соёлбадрахын хоёр үхэр нь шавартай нүхэнд унасан гомдлыг хүлээн авч асуудлыг шийдвэрлэж өгсөн.

Компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлтэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний үр дүнд сүүлийн жилүүдэд иргэдийн шаардлага, гомдлын тоо багасч, харин хамтын ажиллагааны санал хүсэлтийн тоо эрс нэмэгдэж байна.

Нийт ирсэн өргөдөл, гомдол



Цогтцэций сум дахь зөвлөл нь нийгмийн олон талын бүлгийн төлөөллөөс бүрдсэн долоон гишүүнтэй бөгөөд тайлант онд улирал тутам тогтмол хуралджээ. Зөвлөлийн гишүүдийн хувьд компанийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд оролцогч талууд хүлээн зөвшөөрдөг болсон тул зорилтот төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллахыг зорьж ажиллах болсон. Энэ хүрээнд 2023 онд зөвлөлийн гишүүд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд байгаль орчин, экологийн боловсрол олгох нөлөөллийн ажил хийх санаачлага гаргаж, “Бяцхан Экологич” төслийг эхлүүлж, Цогтцэций

сумын 6, 7, 27, 30-р цэцэрлэгүүдэд бага оврын хүлэмж, хүлэмжний багаж хэрэгсэл, усны сав, мод суулгацууд зэргийг хандивласнаас гадна ургамал ногоог хайрлан

хамгаалах, тарьж ургуулах анхан шатны сургалтыг явуулж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Орон нутгийн тогтвортой хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төвөөс 560 км алслагдсан бүс болох Өмнөговь аймгийн Цогтцэций сум буюу Ухаа худагийн хөндийд өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг

өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тайлант онд нийт 25.3 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон орон нутгийн худалдан авалт, хандив тусламжид зарцуулсан байна.


ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2023

	төгрөг
I. Орон нутгийн дэд бүтэц	4,432,069,984
Ус хангамж	2,288,000,000
Ус цэвэршүүлэх байгууламж	2,144,069,984
II. Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	1,975,122,000
Боловсролыг дэмжих хөтөлбөр	474,000,000
Байгаль орчныг дэмжих хөтөлбөр	991,122,000
Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр	70,000,000
Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр	10,000,000
Соёлын өвийг дэмжих хөтөлбөр	430,000,000
III. Хандив, тусламж (Өмнөговь)	4,795,805,250
Орон нутагт хөл бөмбөгийн талбай зүлэгжүүлэх	260,000,000
Орон нутгийн ТББ-уудын хамтын ажиллагааг дэмжих	90,000,000
Эрчим хүчний нүүрсний дэмжлэг	4,144,742,250
“Сайн хөрш” хөтөлбөр	229,875,000
Хандив тусламж	71,188,000
IV. Орон нутгийн худалдан авалт	14,100,000,000
V. НИЙТ	25,302,997,234

ОРОН НУТГИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал байдаг. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд аль болох онцгойлон анхаарч, хамтран ажиллахыг нэн тэргүүнд зорьдог.

ОРОН НУТГИЙН ХУДАЛДАН АВАЛТ



Энержи Ресурс компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд дотоодын нийт 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн байна. 2023 оны хувьд бид нийт 450 гаруй аж ахуйн нэгжээс 1.8 их наяд төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 90-ээс дээш хувь нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байлаа. Өмнөговь аймгийн хэмжээнд 2023 онд орон нутгийн 27 иргэд, аж ахуйн нэгжээс нийт 14.1 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ. Манай нийт ажиллагсдын 35 орчим хувь нь орон нутгийн иргэд байдаг тул ажиллагсдын цалин урамшуулал, нийгмийн хангамжаар дамжин сум орон нутгийн эдийн засагт томоохон нөлөөтэй байдаг. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төсөл, хөтөлбөрөө тогтвортойгоор үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүгүй зээл олгосоор байна. Уг хөтөлбөрийн хүрээнд сүүлийн арван жилийн хугацаанд Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо сумдын жижиг, дунд бизнес эрхлэгч **100 ОРЧИМ ИРГЭНД НИЙТ 780 ГАРУЙ САЯ ТӨГРӨГИЙН ХҮҮГҮЙ ЗЭЭЛ ОЛГОЖЭЭ.**

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компаниас нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлсээр ирсэн. Үүсэн байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэлх арав гаруй жилийн хугацаанд:

- Орон нутгийн боловсролыг дэмжих
- Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
- Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- Соёлын өвийг хамгаалах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах

гэсэн үндсэн чиглэлүүдээр нийгмийн хариуцлагын нийт 50 гаруй бие даасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ.

Тайлант онд орон нутгийн засаг захиргаа, малчид, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтайгаа хамтран орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, уламжлалт ажлуудыг үргэлжлүүлж, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа.

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд компанийн орон нутагт оруулсан бүхий л хөрөнгө оруулалт нь тус бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, цаашлаад орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд болон компанид үр өгөөжөө өгөх зорилго агуулагдаж байдаг. Компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, хөтөлбөрүүдэд шууд байдлаар 10,000 орчим хүн хамрагдаж байна.

Орон нутгийн боловсролын хүртээмжийг дэмжих хөтөлбөр



Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2013 оноос хойш үе шаттай хэрэгжүүлж байна. Тайлант онд бид хөтөлбөрөө өргөжүүлж, эцэг эхчүүдээс авсан судалгааны дагуу орон нутгийн сурагчдад хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөр олгох, сурлагын хоцрогдол

арилгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Мөрөөдлийн хөтөч” сургалт хөгжлийн төвийг Цогтцэций суманд шинээр байгуулаа. Тус **ТӨВД ОДООГООР ЕБС-ИЙН 4-12 -Р АНГИЙН НИЙТ 160 ОРЧИМ ХҮҮХЭД ХАМРАГДАЖ** буй бөгөөд Улаанбаатар хотоос болон аймаг, орон нутгийн туршлагатай багш нарын баг ажиллаж англи болон хятад хэл, математик, EQ болон кодингийн чиглэлээр хичээл зааж байна. Улаанбаатар хотоос ур чадвар сайтай багш нарыг урилгаар авчирч, компанийн зүгээс “Цэций” хороолол дахь тохилог орон сууцаар хангаж нийгмийн асуудлыг нь шийдвэрлэлээ.

Мөн ажиллагсдыг гэр бүлээр нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд Цогтцэций сумын 7-р цэцэрлэгтэй Хамтран ажиллах гэрээний дагуу хүүхдийн цэцэрлэгийн зориулалт бүхий 520м2 талбайтай иж бүрэн тохижуулсан байрыг таван жилийн хугацаатайгаар үнэ төлбөргүй ашиглуулж байна. Ингэснээр хөдөө орон нутгийн сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, 140 хүүхдийг цэцэрлэгт хамруулж байна.



Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга Г.Бацмаа

“Манай сум одоогийн байдлаар албан ёсны бүртгэлтэй 9,000 гаруй иргэдтэй. Ойролцоогоор 25-30 мянган хүн шилжилт хөдөлгөөнтэй амьдардаг. Уул уурхай дагасан шилжилт хөдөлгөөн, төвлөрөл ихтэй манай суманд боловсролын хүртээмж, чанарын асуудал гол хөндөгддөг асуудлын нэг. Хөдөлмөрийн насны олон залуу гэр бүл хүүхдүүддээ орон нутагт чанартай боловсрол эзэмшүүлэх хүсэл сонирхолтой байдаг. Энэ үед Энержи Ресурс компаниас сургалтын төв нээж байгаа нь цаг үеэ олсон, сум оронд тулгамдаж байгаа асуудлыг соргоогоор мэдэрч хийсэн ажил гэж болж байна.”

“Амралтаараа ажиллая” оюутны зуны хөтөлбөр

Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханхонгор, Баян-Овоо, Цогт-Овоо сумын оюутан залууст амралтаараа ажил эрхлэх, нэмэлт орлого олох боломж олгох, улмаар тэдгээрийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг тайлант онд амжилттай хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд зуны турш Ухаа худаг уурхайн алба нэгжүүд болон Цогт-Овоо, Ханхонгор

сумдад **НИЙТ 33 ОЮУТНЫГ МЭРГЭЖЛИЙНХ НЬ ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ДАДЛАГАЖУУЛЖ АЖИЛЛУУЛСАН.** Цогтцэций, Баян-Овоо сумдын харьяат оюутнууд Ухаа худаг төслийн мод үржүүлгийн талбай, оффис, төслийн нэгжүүдэд ажиллаж, ажил хөдөлмөрийн туршлага хуримтлуулсан бол Ханхонгор, Цогт-Овоо сумдын оюутнууд сум, орон нутгийнхаа ногоон байгууламж, бүтээн байгуулалтад өөрсдийн хувь нэмрээ оруулан ажилласан байна.



Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр

Цогтцэций суманд хүн амын төвлөрөл нэмэгдэж, ялангуяа залуу гэр бүлийн бага насны хүүхдүүд ихээр нэмэгдэж байгааг харгалзан үзэж 2023 онд Цогтцэций дэхь сум дундын эмнэлэгтэй хамтран Улаанбаатар хотоос ЭХЭМҮТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарыг

урьж орон нутгийн хүүхдүүдэд үзлэг, оношилгоо хийх ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 900 орчим хүүхэд үнэ төлбөргүй үзлэгт хамрагдаж, 20 гаруй хагалгааны товыг гаргасан чухал үр дүнтэй ажил болсон.



Ухаа худаг баяр наадам 10 дахь жилдээ

Говь нутгийн өв, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, нутгийн зон олонд хүндэтгэл үзүүлэх, орон нутагт шилжин суурьшсан ажиллагсаддаа урам зориг өгөх зорилготой “Ухаа худаг” наадам жил бүр уламжлал болон зохиогдож ирсэн. 2022 оны 8-р сарын 12-13-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд зохион байгуулсан “Ухаа худаг” наадамд нутаг нутгийн хүчит бөхчүүд зодоглож, хурдан хүлгүүд нь шандсаа өргөж, мэргэн харваачид нь цэцээ сорилоо. Тус наадамд улс, аймаг, сумын цолтой 128 хүчит бөх, өсвөрийн 32 бөх,

Энержи Ресурс компанийн ажиллагсдын төлөөлөл 48 бөх хүч үзэн барилдаж, хурдан морины уралдаанд 11 аймгийн, нийт 5 насны 140 шандаст хурдан хүлэг уралдсан юм. Сурын харваанд улс, аймгийн цолтой, чансаа өндөр 103 мэргэн харваач, өсвөрийн 34 харваач оролцлоо. Мөн наадмын үеэр циркийн тоглолт, хүүхдийн дууны уралдаан, үдшийн шоу цэнгээн, амьд хөгжмийн тоглолтууд зохиогдож, нийт 100 гаруй уран бүтээлч оролцсон байна.

Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Уурхайн нөлөөллийн бүсийн малчид, иргэдийн эрхийг хүндэтгэн тэдний өөрсдийн сонгосон жижиг, дунд бизнесийг дэмжиж, хамтран хөгжүүлэх зорилгоор “Орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр” -ийг 2014 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд жижиг, дунд бизнес эрхлэхэд нь 10 хүртэлх сая төгрөгийн зээлийг хүүгүй олгож, санхүүжилт ба эрсдлийг компаниас 100% хариуцан ажилладаг. Тус хөтөлбөрийн зээлийн санд зориулан 2014-2024 онд 300 сая төгрөгийг орон нутгийн Хас банкинд байршуулсан бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 99 иргэнд 784 сая төгрөгийн хүүгүй зээлийг гурав хүртэл жилийн хугацаатай олгожээ. 2023 оны хувьд **ЦОГТЦЭЦИЙ СУМЫН 12 ИРГЭН, НЭГ ХОРШООНД НИЙТ 140 САЯ ТӨГРӨГИЙН ХҮҮГҮЙ ЗЭЭЛ ОЛГОН** өрхийн бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүллээ. Зээлийн хөтөлбөрт хамрагдагч иргэд, аж ахуйн нэгжүүд маань зээлдээ маш

хариуцлагатай хандаж, зориулалтын дагуу захиран зарцуулдаг бөгөөд бодит үр дүн харагддаг нь манай хөтөлбөрийн гол давуу тал, ач холбогдол юм.

Түүнчлэн 2023 оны 5-р сард тус хөтөлбөрийн үр дүнг олон нийтэд танилцуулах тайлагнах зорилгын хүрээнд Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран “Хамтдаа Хөгжье” жижиг, дунд бизнесийн анхдугаар форумыг амжилттай зохион байгууллаа. Форумд Цогтцэций сумын 100 гаруй бизнес эрхлэгч оролцон үзэсгэлэн худалдаа гаргаж, бараа бүтээгдэхүүнээ сурталчилж, борлуулснаас гадна хэлэлцүүлэг өрнүүлж, орон нутагт бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, туршлагаасаа хуваалцсан юм. 2014 оноос эхлэн арван жилийн хугацаанд тогтвортой үргэлжилж буй уг зээлийн хөтөлбөр нь орон нутгийн жижиг бизнесүүдэд бодит дэмжлэг болж, үр дүнтэй хэрэгжиж буйг форумд оролцсон бизнес эрхлэгчид онцолж байлаа.



Цогтцэций сумын бизнес эрхлэгч Н.Алтантуяа:

“2018 онд гэр бүлийн хүнээ дагаад Цогтцэций суманд ишлжиж ирсэн. 2019 онд хэрчсэн гурил үйлдвэрлэж, өрхийн бизнесээ эхлүүлж, цех нээсэн. 2023 онд Энержи Ресурс компанийн жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, зургаан сая төгрөгийн хүүгүй зээл авч, тоног төхөөрөмж худалдаж авснаар бизнесээ өргөжүүлж талх, боов хийдэг болсон. Одоо орон нутгийн таван хүнийг ажлын байраар хангаж байна. Тодорхой үйлчлүүлэгчидтэй болсон. Манай сумын дэлгүүрүүд талх, боорцгоо зөвхөн нийслэлээс авдаг байсан бол одоо бидний хийсэн бүтээгдэхүүнээс авдаг болж, тодорхой хүрээнд танигдаж байгаад баяртай байна”.

Газар тариалан, хүнсний ногоо тариалалтыг дэмжих төсөл

Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэлтийг дэмжих урт хугацааны бодлоготойгоор газар тариалангийн төслийг 2011 онд ойн зурваст эхлүүлсэн. Одоогийн байдлаар долоон га талбайд ногоо тарих боломжийг бүрдүүлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд таван га талбайд айл өрх, албан байгууллагууд төмс, хүнсний ногоо тариалж байна. **2023 ОНД ДӨРВӨН ГА ТАЛБАЙД 15 ӨРХ, НЭГ БАЙГУУЛЛАГА 20 ГАРУЙ ТӨРЛИЙН ТӨМС ХҮНСНИЙ НОГОО ТАРИАЛЖ НИЙТ ГУРВАН ТОНН УРГАЦ ХУРААН АВСАН БАЙНА.**

Ногооны талбайн усалгаанд нийт 17,400 м3 ус зарцуулсан ба компанийн зүгээс усаар үнэ төлбөргүй хангахаас гадна талбайд туслах ажилтан ажиллуулж айл өрхүүдийг ногоо тарих, хураахад дэмжлэг үзүүллээ. 2023 онд талбайн хүнсний ногооны усалгааг дуслын усалгааны системд шилжүүлснээр усыг хэмнэх, тариаланчдын ажлыг хөнгөвчилж өгсөн. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор “Алтан намар-2023” ургацын баяр, үзэсгэлэн худалдааг Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд 100 орчим иргэд, аж ахуйн нэгж оролцлоо.



“САЙН ХӨРШ” ХӨТӨЛБӨР

Бид сум орон нутгийн иргэдэд тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг хөнгөвчлөх, тусламж үзүүлэх, Цогтцэций сумын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээнд байнгын дэмжлэг үзүүлэх зэрэг үүднээс урт хугацааны “Сайн хөрш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай тогтмол хамтран ажилладаг. Тайлант онд иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч,

Эрчим хүчний нүүрсний хангалт

Энержи Ресурс компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг 24 цагийн тог цахилгаанаар найдвартай хангахын зэрэгцээ ойролцоох бусад сумдад тог цахилгааны доголдол үүссэн үед цахилгаан нийлүүлж, сумын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Өмнөговь аймаг болон ойролцоох сумдын өвөлжилтийн хэрэгцээнд зориулан жил бүр 30,000 орчим тонн эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна. Тодруулбал, 2009 оноос хойш Даланзадгадын

нийлүүлэгчидтэй сайн хөршийн харилцааг эрхэмлэж, сумдыг эрчим хүний нүүрсээр хангах, малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг уламжлалын дагуу зохион байгуулж, орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих ажлуудаа тууштай үргэлжлүүлээ.

дулааны цахилгаан станц, Цогтцэций, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ханбогд, Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор сумдын эрчим хүч болон албан газруудын хэрэгцээний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсээр ирсэн. 2023 онд Өмнөговь аймгийн 11 сумдын ДЦС-ууд болон айл өрхүүдэд хамтын ажиллагааны гэрээний хүрээнд нийт 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 24,500 тонн эрчим хүчний түүхий нүүрс болон 49,500 тонн угааж баяжуулсан нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлж, олон айл өрх, албан байгууллагуудыг дулаан өвөлжихөд нь хувь нэмрээ орууллаа.

Ундны цэвэршүүлсэн ус хангамж

Бид ус хангамжийн системийнхээ хүрээнд уурхайн болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Тодруулбал, говийн хатуулаг ихтэй, шууд унданд хэрэглэхэд тохиромжгүй усыг өөрсдийн зардлаар бүрэн цэвэршүүлж, ундны усны стандартад нийцүүлэн нийлүүлдэг. Дунджаар жилд 120,000 м³ цэвэршүүлсэн усыг сумын иргэдэд улсын суурь үнээр нийлүүлж байна. Түүнчлэн Цогтцэций сумын төв, Ажилчдын хотхон, “Цэций” хорооллыг ариутгах татуургын нэгдсэн системд холбосон бөгөөд сумын төвд орчин үеийн, европ стандартын, хоногт 1,200 тонн бохир ус хүлээж авч цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна.

2023 онд Цогтцэций сумын иргэдийн унд ахуйн хэрэгцээнд 143 мянган м³ цэвэршүүлсэн ундны усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөвөөрөөр, иргэд оторчдын малын усалгаанд 2,379 м³, сумын иргэдийн хүнсний ногооны талбайн усалгаанд 17.4 мянган м³ усыг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр, аж ахуйн нэгж,

Өвс, тэжээлийн дэмжлэг

Сүүлийн арав гаруй жилийн турш малчдад өвөл, хаврын хүнд хахир үеийг хохирол багатай даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өвс, тэжээлийн тусламж үзүүлсээр ирсэн. Жилд дунджаар 9-10 мянган боодол өвс, 50 орчим тонн тэжээл татан авч бэлддэг. 2023 онд нийт 8,500 боодол өвс, 1600 уут тонн хивэг тэжээлийг

Зорилтот бүлгийн дэмжлэг

Сар шинийг тохиолдуулан жил бүр Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын 70-аас дээш насны ахмад буурлуудад хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. 2023 онд Цогтцэций, Ханхонгор, Баян-Овоо сумдын 70-аас дээш насны нийт 310 ахмадад хүндэтгэл үзүүлж, хүнсний багц гардууллаа. Мөн Ахмадын баярыг угтан Цогтцэций сумын 186 ахмадыг хүлээн авч, урлагийн тоглолтоор бэлэг барилаа.

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний барааны үнийн

байгууллагуудад 38.8 мянган м³ усыг тус тус түгээсэн байна. Мөн онд сумын цэвэрлэх байгууламж нь 134 мянган м³ ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөвөөрөөр хүлээн авч цэвэрлэжээ.

Өвөлжилтийн хэрэгцээний нүүрсний дэмжлэг (2023)

Эрчим хүчний түүхий нүүрс Угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс

24,500 **49,500**

ТОНН ТОНН

Орон нутгийн ундны усны хэрэгцээнд (2023)

143,000 м³

Цэвэршүүлсэн ундны ус



худалдан авч, Цогтцэций сумын дөрвөн багийн 430 малчин өрх, нөлөөллийн бүсийн 45 өрхөд дэмжлэг үзүүллээ. Мөн Цогт-Овоо сумын өвсний фондод 500 боодол өвс, биотехникийн арга хэмжээнд зориулж 250 боодол өвс тус тус хандивлажээ.

өсөлт нэмэгдэж буйтай холбогдуулан Сумын хөдөлмөр халамжийн албатай хамтран зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Цогтцэций сумын хөдөлмөр, халамжийн албатай хамтран тус сумын 140 өрх айлд хүнсний багцийн хүмүүнлэгийн тусламж үзүүллээ. Хүнсний тусламжийн хүрээнд зорилтот өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, цаашид тогтвортой амьжиргааг нь дэмжих чиглэлд олон төрөлт ажлууд хийхээр төлөвлөж байна.

IX. ШАГНАЛ

2023 онд Энержи Ресурс компанийн хувьд улс орны эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж, томоохон татвар төлөгч, ажил олгогчийн байр сууриа хадгалсныг төрийн ба холбогдох байгууллагуудаас өндрөөр үнэлж, талархал хүлээлээ.

Тус компани нь сүүлийн 14 жилийн турш Монгол Улсын “ТОП-100 ахуйн нэгж”, “Оны онцлох 10 аж ахуйн нэгж”, “Шилдэг татвар төлөгч 10 аж ахуйн нэгж” гэсэн шалгаруултад эхний аравт тасралтгүй эрэмбэлэгдэн тэргүүлэх байр сууриа хадгалж ирлээ.



ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙН ШАЛГАРУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хамтран нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийг эрэмбэлж, өргөмжлөх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

2010	IV байр	2018	V байр
2011	III байр	2019	V байр
2012	IV байр	2020	V байр
2013	IV байр	2021	X байр
2017	V байр	2022	III байр
		2023	IV байр



ЭНТРЕПЕНЁР 2022- ОНЫ ОНЦЛОХ 10 АЖ АХУЙН НЭГЖ

Бизнесийн салбарт өндөр амжилт гаргаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй онцлох ААН, байгууллага, бизнес эрхлэгчдийг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн тэнхимээс жил бүр шалгаруулж, тодруулсаар ирсэн.

2010	Гранпри шагнал	2018	X байр
2011	IX байр	2019	Мөнгөн меркури
2012	VII байр	2021	Хүрэл меркури
2013	VIII байр	2022	Мөнгөн меркури
2017	VI байр	2023	Мөнгөн меркури



ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ 10 АЖ АХУЙН НЭГЖ

Жил бүрийн 5-р сард Татвар төлөгчдийн өдрөөр Татварын Ерөнхий газраас шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг шалгаруулдаг. Сангийн яам ба Татварын ерөнхий газраас хамтран тодруулдаг уг шалгаруулалтад татварын нэгдсэн дүнгээс гадна татвар төлөгчдийн хариуцлагатай, үлгэр жишээч байдлыг гол шалгуур болгон авч үздэг байна.

2011	V байр	2019	VII байр
2012	I байр	2020	V байр
2013	V байр	2021	VII байр
2014	V байр	2022	IV байр
2018	VII байр	2023	IV байр



Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, Соёлын өвийг дэмжих
хөтөлбөрийн хүрээнд жил бүр зохион байгуулдаг
“Ухаа худаг” наадмын хурдан морины уралдааны үеэр...



Сэнтрал Тауэр 16 давхар, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14200, Монгол Улс

www.energyresources.mn

Галерей кэмп, Цогтцэций сум, Өмнөговь аймаг
46040, Монгол Улс

Утас: 976 7012 2279
Факс: 976 11 322 279